

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын тоот албан бичгийн хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
/2022 оны байдлаар/

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2022 оны байдлаар танилцуулж байна.

Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төлөвлөгөө нь 6 бодлого, 259 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны байдлаар **69.8 хувийн /өссөн дүнгээр 39.3 хувь/** хэрэгжилттэй байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал:

- КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого- 83.1 хувь /өссөн дүнгээр 60.3 хувь/,
- Хүний хөгжлийн бодлого- 63.9 хувь /өссөн дүнгээр 33.3 хувь/,
- Эдийн засгийн бодлого- 64.6 хувь /өссөн дүнгээр 36.0 хувь/,
- Засаглалын бодлого – 70.2 хувь /өссөн дүнгээр 39.2 хувь/,
- Ногоон хөгжлийн бодлого – 65.6 хувь, /өссөн дүнгээр 29.1 хувь/,
- Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого- 71.5 хувийн /өссөн дүнгээр 37.9 хувь/ хэрэгжилттэй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1087 арга хэмжээний 293 нь үр дүнд хүрсэн байгаа бол 320 арга хэмжээ тодорхой үр дүнд гарч эхэлсэн, 307 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 153 арга хэмжээ 2022 оны зорилтот түвшинд хүрэх боломжгүй байна. Тухайлбал:

2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна.

2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.

2.2.3.1.Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.

2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.

2.4.2.3. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина.

2.5.8.9.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.2.1.5.1.Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт.

3.2.7.3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.

3.5.1.8. Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг эхлүүлнэ.

3.5.5.3. Даланзадгад-Ноён чиглэлийн 220 км 110 кВ-ын ЦДАШ барина.

3.6.1.8.9. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ.

3.6.1.10.5. Хөвсгөл аймгийн Ханх сумын Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто замын Цагаан сайрын 72.85 у/м төмөр бетон гүүрийг барина.

3.7.3.5. Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.

3.7.13.2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.

4.1.5.2. Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна.

5.1.12.5. Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц байгуулна.

5.1.12.8. Ус, цаг уурын хяналт- шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлнэ.

6.1.11.4."Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.г.м


Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бодлогын хүрээнд үр дүнтэй хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээ болон салбарын гол статистикийг 2022 оны байдлаар харуулбал:

Нэг. КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:

Дэлхий нийтийн хэмжээнд цар тахлын цаашдын төлөв байдал болон ОХУ болон Украин улсын зэвсэгт мөргөлдөөний үргэлжлэх хугацаа, олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл тодорхой бус, нөхцөл байдал түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ цаг үед ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүн, мах, гурилын хангамж нийлүүлэлтийн хомсдол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлж, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах Гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн хомсдол, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг УИХ-аар 2022 оны 4 дүгээр сарын 15-нд батлуулав.

Улсын хэмжээнд **2022 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар** нийт хүн амын коронавируст халдварын эсрэг вакцины **нэгдүгээр тунд 2,274,082 хүн буюу 69.8 хувь, хоёрдугаар тунд 2,177,423 хүн буюу 66.7 хувь, гуравдугаар тунд 1,052,005 хүн буюу 32 хувь, дөрөвдүгээр тунд 137,119 мянган иргэн** хамрагдсан байна.

Нийт хүн амын коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдалт /2022.08.08/



Хоёр. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:

“Эмнэлэгт үзүүлэх цаг захиалгын 1800-0119 нэгдсэн төв”-ийг нээж, ашиглалтад оруулан, иргэд эмнэлэгт **биеэр очиж цаг авдаг очер, дараалал сарын дотор 86 хувиар буурч**, иргэд чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүллээ. 2022 онд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт улсын хэмжээнд 616,519 хүн хамрагдсанаас 279,213 буюу 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 337 306 буюу 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас хавдрын 184 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 31-45 насны ангилалд 49 тохиолдол буюу 26.6 хувь, 46-60 насны ангилалд 135 тохиолдол буюу 73.4 хувийг эзэлж байна.

Засгийн газрын 2022 оны "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тухай" 218 дугаар тогтоол батлагдаж, тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэгийн зориулалтаар байр түрээслэх, хувийн өмчийн цэцэрлэгийн сул орон тоонд хүүхэд элсүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага дэргэдээ цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжих, орчин үеийн шинэ дэвшилтэт технологи ашиглан гэр цэцэрлэг байгуулах, ачаалал өндөртэй хороодын хувийн өмчийн цэцэрлэгт хувьсах зардлыг хоёр дахин нэмэгдүүлж өгөх, хоолны зардал олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нийслэлийн 3-5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 92,4 хувьд хүрлээ. Дээрх цогц арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд 3-5 насны 228030 хүүхдийн 206,150 буюу 90,4 хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд өнгөрсөн хичээлийн жилээс 4,3 хувиар өссөн байна.

Малчин өрхийн 3-5 насны 47,413 мянган хүүхэд байгаагийн 33,544 /70,7 хувь/ нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж өмнөх хичээлийн жилээс 20,0 хувиар нэмэгдсэн байна. 2022-2023 оны хичээлийн жилд цэцэрлэгийн 24 цагийн үйл ажиллагаатай 82 бүлэгт хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 2044 хүүхэд хамрагдаж байна.

Төрийн хэмнэлтийн бодлогын үр дүнд хэмнэгдсэн зардлыг үнийн өсөлтөөс сэргийлэх, иргэдийнхээ амьжиргааг дэмжих дараахь арга хэмжээнд 2022 он дуустал зарцуулахаар боллоо.

- Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн нэг сая төгрөг болон түүнээс доош орлоготой даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг сар бүр буцаан олгох,

- Хүүхдийн 100 мянган төгрөгийг мөнгөн хэлбэрээр үргэлжлүүлэн олгох,

- Дотооддоо хүнс үйлдвэрлэх, хүнсний нөөц бүрдүүлэх, хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангах, дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорь барихад зориулж нэг их наяд төгрөгийн гурван хувийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасыг улсын төсвөөс олгох,

- Импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосны үнийн өсөлтийн дарамтыг бууруулах зорилгоор импортын гаалийн албан татвараас чөлөөлөх,

- Дотоодод үйлдвэрлэсэн ургамлын тосыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээ багтлаа.

Гурав. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Манай хөрш БНХАУ-д эрчимжээд буй цар тахлын нөлөө болон мөн хөрш ОХУ болон Украины дунд үүссэн дайн, хямралт байдлаас үүдсэн дэлхий нийтэд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсч инфляцийн эсрэг төв банкууд бодлогын хүүгээ өсгөж байгаа энэ үед Засгийн газраас эдийн засгаа сэргээхэд чиглэсэн боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд -3.8 хувьд хүрч унаад байсан эдийн засаг оны эцэст 4.0 орчим хувьд хүрч сайжирсан байна.



Инфляцын түвшин 2021 оны 2 дугаар улирлаас идэвхжиж, 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар **13.2 хувьд хүрээд байна**. Хилийн хязгаарлалт, хил дээрх ачаа барааны бөөгнөрөл, малын гоц халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлт, гадаад зах зээл дээрх тухайн барааны үнийн өсөлт зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт инфляцын дийлэнхийг бүрдүүлж байна.




Монгол Улсын Засгийн газраас экспортыг эргэн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны эхний хагаст 8.1 сая тонн буюу өмнөх оноос 12.7 хувиар агшаад байсан нүүрсний экспорт 2022 оны эцэст 31.6 сая тоннд хүрч 2021 оноос даруй хоёр дахин өссөн байна. Зэсийн баяжмалын хувьд 1.4 сая тонн экспортолж, өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ингэснээр АМНАТ-ийн орлого 2.7 их наяд төгрөгт хүрч, уул уурхайн орлого 4.1 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 750 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Засгийн газраас 2022 оны аравдугаар сард “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол гаргаж хэрэгжүүлсэн нь гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлж улмаар “Эрдэнэс Тавантолгой” ТӨХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иуд болон “Оюу толгой” ХХК нийт 1.1 тэрбум гаруй ам.доллар улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” ТӨХК дээрх тогтоол батлагдсанаас хойш арванхоёрдугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд 588.5 сая орчим ам.долларын үнийн дүн бүхий 6.6 сая тонн нүүрс борлуулжээ. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн шийдвэрээр “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам” батлагдсанаар экспортын нүүрсийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан ил тод нээлттэй арилжаалж эхлээд байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1376 төсөл, арга хэмжээний 1,697.3 тэрбум төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1369 төсөл, арга хэмжээний 1,393.7 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд

долоон төсөл, арга хэмжээний 303.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2022 оны арванхоёрдугаар сарын 31-ний байдлаар 1,539.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор 90.7%-тай гарсан байна.



Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн БНХАУ-ын эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах, улмаар манай экспортын бүтээгдэхүүний гадаад эрэлт муудах эрсдэл нэмэгдсэн, Украин дахь дайн, үүнээс улбаатай эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ үргэлжилсэн хэвээр, глобал түвшинд инфляцын өсөх дарамт үргэлжлэхээр байгаагаас төв банкууд мөнгөний бодлогоо илүү хурдан хатууруулах төлөвт шилжүүлж байгаа, инфляц 2022 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 16.1 хувь хүрч өссөн, 2022 оны эхний улиралд худалдааны тэнцэл муудсанаар урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3.4 дахин тэлсэн, банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, гадаад зах зээлийн суурь хүү өсч байгаа зэргээс хамаарч төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах зорилгоор 2022 онд бодлогын хүүг 4 удаа өсгөж 13 хувьд хүргээд байна.




Монголбанк болон арилжааны банкуудын эх үүсвэрээр 2021 онд нийт 1 их наяд төгрөгийн зээлийг 13 мянга орчим зээлдэгчид олгож байсан бол 2022 онд 730 орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 8 мянга орчим зээлдэгчид олгоод байна. Цар тахлын хуулийн дагуу хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оныг дуустал 5 удаа хойшлуулсан. Сүүлийн буюу 5 дахь удаагийн төлбөр хойшлуулалтаар 3.4 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63,171 зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлууллаа.

2022 оны 12 дугаар сарын байдлаар гадаад валютын нийт **албан нөөц 3.4 тэрбум ам.доллар** байна. Энэ нь импортын 4-5 сарын нөөцийг хангахаар байна.



Засгийн газраас 2020 онд авч хэрэгжүүлсэн “Номад” өрийн зохицуулалтын арга хэмжээ, 2021 онд авч хэрэгжүүлсэн “Сенчири” өрийн зохицуулалтын арга хэмжээний үр дүнд 2022 оны арванхоёрдугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын хоёрдугаар транч болох 10 жилийн хугацаатай, 5.125 хувийн хүүтэй, нийт 1.0 тэрбум ам.долларын дийлэнх хэсгийг дахин санхүүжүүлж, үлдээд байсан 136.8 сая ам.долларын төлбөрийн эргэн төлөлтийг 2022 оны арванхоёрдугаар сарын 5-нд бүрэн төлж барагдуулсан. Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийг эргэн төлүүлэх ажлыг эрчимжүүлснээр 2022 онд 994.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Ингэснээр Засгийн газрын баталгаатай Самурай бондын эргэн төлөлтийг төлөх мөнгөн хөрөнгийг 100 хувь бүрдүүлж, цаашлаад 2022 оны эхэнд 1.3 хувь байсан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (CAR)-ийг зохистой түвшинд хүргэж тус банк дампуурах эрсдэлээс бүрэн гараад байна.

Гадаад валютын ханш



Амгалангийн дулааны станцын 116 мегаваттын өргөтгөлийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 16-нд эхлүүлсэн бөгөөд төсөл хэрэгжсэнээр цагт 116 мегаватт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэж, нийслэл Улаанбаатар хотын хүн амын 30 гаруй хувь амьдардаг Баянзүрх дүүрэг болон Улиастай орчмыг дулааны найдвартай эх үүсвэрээр хангаж, дулааны III цахилгаан станцын ачааллыг хуваалцаж, тус станцын хоёрдугаар үе шатны өргөтгөлийн ажлыг эхлүүлэх боломж бүрдэх юм.

Завхан аймгийн Алдархаан сумын нутагт "Борх" 5 МВТ-ын Нарны цахилгаан станц, Улиастай суманд "Цэнгэг" 3.6 МВтц хүчин чадалтай эрчим хүч хуримтлуурын станц 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ашиглалтад орлоо. Энэхүү нарны цахилгаан станц болон цэнэг хураагуурын станцыг ашиглалтад оруулснаар бүс нутгийн цахилгаан эрчим хүчний хангамж сайжирч, ард иргэд, байгууллагыг чанартай цахилгаанаар хангах боломж бүрдэхээс гадна нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг жилд 9,564 тонноор, нүүрс шатаалтыг жилд 6,476 тонноор бууруулж, цэвэр усыг жилд 82,500 тонноор хэмнэдэг ашиг тустай. Монгол Улсдаа хамгийн анхны том чадлын буюу 3.6 МВТ-ын батарей хуримтлуурын системийг амжилттай оруулж чадлаа.

"Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур" төслийн барилга угсралтын ажлыг 2022 оны 8 дугаар сарын 4-нд эхлүүлсэн бөгөөд төсөл хэрэгжсэнээр дэлхийд томд тооцогдохуйц 200 МВт.цагийн хүчин чадалтай Литиум-Ион төрлийн батарей ашигласан хуримтлуурын байгууламжийг суурилуулж, 110 кВ-ын "Сонгино" дэд станцад холбоно. Ингэснээр Монгол Улсын Төвийн бүсийн эрчим хүчний системийн тогтвортой, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ. Мөн нэгдсэн сүлжээний дутагдлыг нөхөх, 200 МВт хүртэл чадлыг нийлүүлж, импортын эрчим хүчийг бууруулна.

Засгийн газар хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах замаар экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, голлох боомтууд болох Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод автомат удирдлагатай чингэлэгт тээвэр (AGV) нэвтрүүлж, нэвтрэх машины тоог нэмэгдүүлсэн. Тухайлбал, Булган, Ханги, Замын-Үүд боомтуудаар гарах нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсны үр дүнд эхний хагас жилийн байдлаар 8 сая тонн байсан нүүрсний экспортыг 31.7 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 90.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн зэсийн баяжмалын хувьд 1.4 сая тонн экспортолж, өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улмаар нийт экспортын хэмжээ 12.5 тэрбум ам.долларт хүрч, төлөвлөгөөнөөс даруй 3.5 тэрбум ам.доллараар өссөн байна. Энэхүү үзүүлэлт нь АМНАТ, ААНОАТ-ын орлого нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Татварын орлого 15,568.3 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 1,710.7 тэрбум төгрөгөөр буюу 12.3 хувиар давж биелсэн байна.

Экспортын гол нэр төрлийн бараа	2019	2020	2021	2022
Зэсийн баяжмал (мян.т)	1,404	1,395	1,283	1,453
Төмрийн хүдэр, баяжмал, пирит (мян.т)	8,449	8,202	7,106	4,732
Нүүрс (мян.т)	36,604	28,677	16,138	31,814
Боловсруулаагүй нефть (мян.барр)	6,545	4,071	4,349	2,606

Нэгдсэн төсвийн нийт орлого 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18,593.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 11.3 хувиар буюу 1,886.9 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оны мөн үеийнхээс 25.5 хувиар буюу 4,337.9 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн үзүүлэлттэй байна. 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 17,198.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөөнөөс 7.8 хувь буюу 1,244.0 тэрбум төгрөгөөр давж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,487.1 тэрбум төгрөгөөр буюу 35.3 хувиар нэмэгдсэн байна.

Оюу Толгой төслийн гаднын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийх ажлын явцад үр дүн гарч, хөрөнгө оруулагч тал өмнө нь үүсэн 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь барагдуулж, ирээдүйд тооцогдох 22 тэрбум ам.долларын өр үүсэхгүй болсноор Оюу толгой төслийн Засгийн газрын эзэмшлийн 34 хувь Монгол Улсад үнэ төлбөргүй ирэх боломжтой болсон, мөн гүний уурхайн үйлдвэрлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 22-нд эхлүүлээ.


Дөрөв. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд:

Монгол Улсад 2022 оны 12 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд гадаадын 290 мянга орчим жуулчин ирж, нийт 428 сая ам.долларын орлого оруулан аялал жуулчлалын салбар сэргэж эхэллээ.

Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажлын хүрээнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж, нийт 30 бүтээгдэхүүнд зээл олгож байгаа бөгөөд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жилийн 9 хүртэл хувийн хүүтэйгээр санал болгож байна. Ногоон зээлийг дэмжих чиглэлээр 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөн иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэй ногоон зээл олгож байна.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 309 иргэн, 11 аж ахуй нэгжид 854,6 сая төгрөгийн зээлийн хүүний санхүүжилт олгосон байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр 21 аймаг, нийслэл нийт 680 сая ш, уул уурхайн томоохон 21 аж ахуйн нэгжүүд 608.5 сая ш, банк санхүүгийн байгууллагууд болон бусад аж ахуйн нэгжүүд нэгдэн 17 төлөөлөл 88.6 сая ш мод тарихаар амлалт өгсөн. 2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд мод тарих ажилд 355923 иргэн, 16104 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, нийт 10129.0 мян.ширхэг мод, сөөгийг тарьсан.



Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2022 оны 22/05 дугаар тогтоолоор агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 14 арга хэмжээнд 23.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Аймгуудын нам даралтын усан халаалтын зуухны янданд утаа шүүгч суурилуулахад 3.3 тэрбум, “Таван толгой түлш” ХХК-ий сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд 2.1 тэрбум, 6 аймгийн зорилтод бүлгийн 6600 айл өрхөд угаарын хий мэдрэгч суурилуулахад 988.7 сая, нийслэлийн авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисыг бууруулахад 237.9 сая, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зарим цэцэрлэг, сургуулийн түүхий нүүрсээр ажилдаг нам даралтын усан халаалтын зууханд технологийн шинэчлэл хийж, цахилгаан халаагуур, хийн түлшинд шилжүүлэхэд 2.7 тэрбум, Дундговь, Завхан, Өвөрхангай, Дархан-Уул аймагт байгуулах сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд 8.0 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Тав. Засаглалын бодлогын хүрээнд:

Төрийн хэмнэлтийн тухай анхдагч хуулийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аар батлагдаж хөшөө дурсгал, угтах хаалга, дэд болон орлогч дарга нарын орон тоо, автомашины хэрэглээг хязгаарласан нь төсвийн сахилга хариуцлагыг чангатгах, төрийн үрэлгэн байдлын эсрэг соёл, чиг хандлагыг тогтооход үр дүнтэй ажил боллоо. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд 2022 онд урсгал зардлаас 189.1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 156.4 тэрбум төгрөгийг тус тус хэмнэсэн бол 2023 оны төсөвт нэг их наяд төгрөгийн зардлын нөлөөлөл үүсэх байсныг зогсоож чадсан байна.

Төрийн үйлчилгээний “e-Mongolia” системд 71 төрийн байгууллагын 806 үйлчилгээг холбосон бөгөөд 1,484,723 хэрэглэгч бүртгүүлэн, 20,767,298 удаа цахим хэлбэрээр төрийн үйлчилгээ авснаар, 123 тэрбум төгрөгийн шууд бус зардал хэмнэжээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас эрхлэн гаргадаг Цахим засаглалын хөгжлийн индексээр 2022 онд 18 байраар урагшилж, 74 дүгээр байрт орсон байна.

Зөвшөөрлийн тухай хуулийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталсан. Хууль батлагдснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл, жагсаалт болон эдгээртэй холбогдох суурь харилцаа тодорхой болсон. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал болон зах зээлийн харилцаанд оролцогч, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй төрөөс аливаа зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод болгож, цахимаар зохион байгуулах, хэн нэгэн албан тушаалтан дураараа зөвшөөрөл бий болгох болон зөвшөөрлийн тоо, төрлийг нэмэгдүүлэхийг хориглох заалтыг тусгасан. Энэхүү хуулиар төрөөс олгодог зөвшөөрлийн тоог 5 дахин бууруулсан.

Төрийн өмчийн хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон нийтийн хяналтад оруулах зорилгоор 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийг нээлттэй худалдах жагсаалтыг баталлаа. Үүнд: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ болон авто зам арчлалтын компаниуд багтсан. “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь нийт хувьцааныхаа 34 хувь буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгөөр тогтоосон үнийн аргаар олон нийтэд санал болгож, 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн арилжааг 2022 оны 12 дугаар сарын 26-нд эхлүүллээ.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Гадаад хэргийн сайд Ван И манай улсад 2022 оны 8 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийж, Гашуунсухайт-Ганцмод төмөр замын холболт, Хятадын далайн боомтуудаас Монгол Улсыг зорих галт тэрэгний нэг өдрийн цувааны тоог тогтмолжуулах, Замын-Үүд-Эрээн боомтын төмөр замын галт тэрэг солилцооны хэмжээг нэмэгдүүлэх, Ханги-Мандал боомтын төмөр замаар холбох асуудлаарх манай талын хүсэлтийг хятадын тал анхааралдаа авч, дотоодын холбогдох байгууллагатайгаа ярилцахаа илэрхийлэв. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн бүтээн байгуулалтыг хоёр тал эрчимжүүлэхээр тохиролцов.



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш 2022 оны 8 дугаар сарын 8-11-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Эгийн голын усан цахилгаан станцын талаар ярилцаж, ноён Антонио Гутерреш НҮБ энэ тал дээр бодлогын дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.

Зургаа. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд:

10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/ төслийг БНСУ-ын зээлээр хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 2015 оны 459 дүгээр тогтоол анх батлагдаж, 2018 оны 12 дугаар сард хоёр улсын Засгийн газар хооронд Зээлийн гэрээг байгуулсан. Барилга угсралтын ажлын тендерийг 2021 онд зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан Бюксан Инженеринг компанитай 2021.12.27-ны өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлыг дээрх аймгийн төвд 2022 оны 05 дугаар сарын 06- наас 05 дугаар сарын 23-ны өдрүүдэд эхлүүлсэн. БУА-ыг 22 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих” төсөл амжилттай хэрэгжиж байна. 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд. Үүнд: 1. Ус хангамжийн баруун эх үүсвэрийн ус гүн цэвэршүүлэх байгууламжийн барилгын газар шорооны ажил 85 хувь; 2.Түр барилгын ажлууд 98 хувь; 3.Барилгын хашаажуулалт, түр зам, гүний худаг гаргах, түр цахилгаан хангамжийн ажлууд 100 хувь бүрэн дууссан; 4.Газрын доорх усны ашиглалтын цооног өрөмдөх, тоноглох, ус дамжуулах хоолойн барилга угсралтын ажлын олон улсын тендерт шалгарсан Израил улсын Varan групптэй 2022.05.26-нд гэрээ байгуулсан 100 хувь; 5.УСУГ-т лабораторын тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 90 хувь; 6.УБ хотын төвлөрсөн сүлжээнд холбогдсон 180 орчим ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах тендерийг зохион байгуулж байна.

Баруун бүсийг хямд, чанартай цементээр бүрэн хангах “Ховд эко цемент” 2022 оны 11 дүгээр сарын 04-нд ашиглалтад орж цемент үйлдвэрлэж эхэлжээ. Ингэснээр баруун таван аймгийн иргэд, аж ахуй нэгж байгууллагууд цементийг Улаанбаатар хотын үнээр авах боломж ийнхүү нээгдэж байна. Тус үйлдвэр нь хоногт 1200-1300 тнцемент үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд жилд 300 мянган тонн цемент үйлдвэрлэж баруун бүсийн хэрэгцээг хангах юм.

2022 онд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл” -ийн хүрээнд Дорнод аймгийн Дашбалбар сум, Чулуунхороот сум, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан Хөвсгөл аймгийн Ханх зэрэг 6 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажил хийгдэж байна. Энэхүү ажил хийгдэж дууссанаар Монгол улсын 330 сум бүгд шилэн кабелийн сүлжээнд холбогдож дуусна.

Та бүхэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцна уу.